

БНХАУ-ЫН ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГЫН СУДАЛГАА: ХЯТАДЫН ДЭГ СУРГУУЛИЙН ҮЗЭЛ ХАНДЛАГА БА ОНЦЛОГ

Доржсүрэнгийн Уянга, Жамъянгийн Баттөр**

Abstract: In the 21st century, the strategic importance of soft power, a country's ability to attract and influence others through its culture, values, and foreign policy, has grown alongside traditional hard power (military and economic strength) in international relations. This concept was first introduced by Joseph Nye, who defined soft power as “the ability to influence others to get what you want through attraction rather than coercion”.

Over the past decade, the People's Republic of China has vigorously pursued soft power as a key component of its national development strategy and foreign policy agenda. China aims to enhance its global influence through a wide range of channels, including traditional culture, philosophy, arts, media, digital platforms, and educational cooperation. The concepts of “enhancing national cultural soft power” (提高国家文化软实力) and the “Chinese Dream” (中国梦) have taken a central role in state policy, reflecting an effort to construct a unified political and cultural narrative.

This article seeks to examine the theoretical foundations of China's soft power strategy and assess its current development trajectory and future directions.

Keywords: Soft power, Sharp power, China's foreign policy, Cultural diplomacy, China's soft power, Chinese Dream

I. Онолын үндэс

Ж.Най нэгэнтээ “Нийгмийн шинжлэх ухааны суурь ойлголтуудын нэгэн адил “хүч” гэдэг ойлголт маргаантай байдаг. Хүн бүр энэ үгийг ашигладаг ч нийтээр хүлээн зөвшөөрсөн ганц тодорхойлолт гэж байдаггүй. Хэн нэгний ашиглаж буй тодорхойлолт түүний ашиг сонирхол, үнэт зүйлтэй шууд хамааралтай. Зарим хүн хүчийг “өөрчлөлт хийх эсвэл эсэргүүцэх чадвар” гэж үздэг бол, зарим нь “өөрт хэрэгтэй үр дүнд хүрэх чадвар” гэж тодорхойлдог. Хүч бол ямар нэг зүйлийг хийх чадвар бөгөөд нийгмийн нөхцөлд бусдад нөлөөлж, хүссэн үр дүндээ хүрэх чадвар юм. Хүссэн зүйлдээ хүрэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг ба эдгээр нь тухайн харилцааны нөхцлөөс хамаарч өөр өөр байдаг.” хэмээн зөөлөн хэмээн тодотгосон хүчийг хэрхэн ойлгож болохыг энгийнээр тодорхойлон тайлбарласан байдаг (S.Nye, 2021)

Хэн нэгэн “хүчтэй” гэж хэлэхийн тулд: Хэнд нөлөөлөх гэж буй? Ямар сэдвээр нөлөөлөх вэ? гэсэн хоёр асуултад хариу өгөх шаардлагатай. Хүч гэдэг нь шалтгаан гэдэг үгтэй адил хэнд хэрхэн гэсэн үйл явдлын хоорондын холбоог бидний сонирхолд үндэслэн онцолж хардаг. Хүч гэдэг зөвхөн нөөц биш; харин нөөцийг үр дүн болгож хувиргах чадвар юм. Тухайн нөхцөлд ямар “тоглоом” явагдаж байгаа, тэр дотор ямар нөөц чухал болохыг ойлгох чадварыг

* Доржсүрэнгийн Уянга. МУИС-ийн Олон улсын харилцааны тэнхимийн магистрант duyanga261@gmail.com

* Жамъянгийн Баттөр. МУИС-ийн Олон улсын харилцааны тэнхимийн дэд профессор battur_j@num.edu.mn

“харьцуулалт хийх ухаан” буюу “contextual intelligence” гэж нэрлэнэ (Kutz & Bamford-Wade, 2013). Энэ ухаан, чадварыг эзэмшсэн бол цаг, бодит их хүчээ үрэлгүй үр дүнд хүрч болох юм.

Ж.Найн хувьд зөөлөн ба хатуу хүчний ялгааг зан үйлийн спектрээр тайлбарласан байдаг (S.Nye, 2021). Энэ шугамын нэг талд цэвэр албадлага, нөгөө талд татах нөлөө (итгүүлэх, үнэмшүүлэх) оршино. Энэ утгаар хатуу хүчийг “саваа” болон “лууван”-гаар зөөлөн хүчийг “соронзон”-оор зүйрлүүлж болох юм. Зарим зан үйл энэ хоёрын дундах “хил зааг” дээр байж болох ба тэдгээрийг ялгах амаргүй гэж Ж.Най үзсэн. Үүний нэг илрэл нь хурц хүч (sharp power) мөн. Тухайлбал, зарим судлаач зөөлөн хүчийг тийм ч “зөөлөн” биш, тодорхой тохиолдолд албадлага агуулж болно гэж шүүмжилдэг. Жишээлбэл, нөлөөлөгч этгээд бусдын “сэтгэлийг эргүүлж”, сонголтыг хязгаарлах арга хэрэглэх нь зөөлөн хүч биш гэж ярьдаг. Гэвч бодит байдал дээр зөөлөн хүч бусад хүч, хатуу, ялангуяа хурц хүчээс ялгардаг.

Жишээ татан үзвэл, БНХАУ-ын зөөлөн хүчний бодлогын нэг чухал нөөц нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд юм. Дотооддоо Хятадын засгийн газраас үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хатуу журам бүхий хяналт тогтоож, англи хэл дээрх мэдээллийн давтамжийг бууруулах, Хятадын уламжлалт соёлд хандах олон нийтийн сонирхлыг сэргээх явдалд анхаарч байсан. Нэг талаар даяаршлын үйл явцын нөлөөгөөр хэт баруунжих явдлаас сэргийлэх, хятад хэлний үнэ цэнийг хэвээр хадгалах зорилгоор 2010 оны 4-р сараас эхлэн хэд хэдэн үндэсний хууль тогтоогчид, улс төрийн зөвлөхүүд хятад хэлний цэвэр байдлыг хадгалахыг уриалсны дараа засгийн газар англи хэл дээрх зээлсэн товчлолыг ашиглахыг хориглосон гэдгээ зарласан юм. Түүнчлэн ТВ шоу нэвтрүүлгүүдэд Хятадын өв уламжлал, түүх соёлыг заавал шингээх ёстой хэмээсэн.

Иймээс зарим судлаач Хятадын ХМХ-д тулгуурласан олон нийтийн дипломат ажиллагаа нь зөөлөн хүч гэхээс илүү, хурц хүч (sharp power) (түлхүү “хөндлөнгөөс нөлөөлөх, сэтгэлзүйн манипуляци хийх” хүч гэж ойлгодог) хэмээн үзэх болсон. Энэхүү ойлголтыг National Endowment for Democracy (2017) байгууллага анх тодорхойлон гаргаж ирсэн бөгөөд, тэргүүлэгч авторууд болох К.Уолкер, Ж.Людвиг нарын бүтээлүүдээр өргөжсөн юм. Хурц хүч нь зөөлөн хүчний адил соёл, мэдээлэл, үзэл санаагаар дамжин нөлөөлөх шинж чанартай боловч, түүнийг ил тод, эерэг сэтгэл төрүүлэх зорилгоор бус, хяналт тогтоох, үзэл суртлыг тараах, эргэлзээ, төөрөгдөл үүсгэх, хүлээн авагч талын дотоод орон зайд сэтгэл зүйн дарамт үзүүлэх зорилготой хэрэглэдэг хүч юм (Walker & Ludwig, 2017).

Хүснэгт 1: Зөөлөн хүч, хурц хүчний ялгаа

Үзүүлэлт	Зөөлөн Хүч (Soft Power)	Хурц Хүч (Sharp Power)
Зорилго	Сэтгэл татам байдал, итгэлцэл бий болгох	Сэтгэлзүйн нөлөөлөл, манипуляци хийх

Хэрэгслүүд	Соёл, үнэт зүйл, гадаад бодлогын эерэг имиж	ХМХ, цахим сүлжээ, цензур, мэдээллийн хяналт
Хандлага	Идэвхгүй, татах замаар нөлөөлнө	Идэвхтэй, нэвтрэх, хөндлөнгөөс удирдах оролдлого
Хүлээн авагч	Сайн дурын сонирхлоор хүлээж авна	Системчилсэн, үл үзэгдэх хэлбэрээр нөлөөлнө
Жишээ улс	Япон (аниме, J-роп), Франц (франц хэл, урлаг)	Хятад (CGTN, TikTok цензуртай хувилбар), Орос (RT, Sputnik)

Эндээс үзэхэд сайн дурын татагдаж буй харилцаа бол зөөлөн хүч, айдас, шийтгэл, хахууль дээр суурилсан нь хатуу хүч, төөрөгдүүлэлт, хуурамч баримтаар үзүүлсэн нөлөөг хурц хүч гэж ойлгож болно. Зөөлөн хүч тухайн хүнд бодит сонголт үлдээдэг, харин хурц хүч сонголт хийх боломжийг гуйвуулж, шууд биш аргаар тулган хүлээлгэдгээр ялгарч байна.

Хятад улс зөөлөн хүчээ тэлэхийн зэрэгцээ, хурц хүчний элементүүдийг ХМХ болон дижитал платформ-оор дамжуулан нэлээд өргөн хэрэглэж байна. Үүнд:

1. CGTN, China Daily, Global Times зэрэг англи хэл дээрхи төрийн хэвлэлүүд Хятадын албан ёсны үзэл бодлыг гадаад зах зээлд системтэйгээр хүргэдэг.
2. TikTok/Douyin зэрэг платформ Хятадад цензуртай хувилбар ашиглагддаг бөгөөд гадаад платформоор дамжуулан тодорхой агуулгыг дэлгэрүүлэх, эсвэл цензур хийх замаар хурц хүчний хэрэгсэл болдог.
3. WeChat, Xinhua, Baidu, Huawei зэрэг мэдээллийн технологийн компаниуд Хятадын засгийн газрын сонирхолд нийцсэн контент түгээх, мэдээлэл хянах суурь бүтэц бий болгоход оролцож байдаг.
4. “Voice of China” санаачилга (2021 оноос) нь Хятадын дуу хоолойг олон улсад давамгайлсан байдлаар хүргэх стратеги болдог.

Иймд судлаач Уолкер нар хурц хүч нь “зурагт үзүүлэх биш, зурагт орох” гэсэн стратеги юм хэмээсэн (Walker & Ludwig, 2017). Д.Шамбаум өөрийн үнэт зүйлсийг биш, бусдын мэдээллийн орон зайг хянах зорилготой хэмээн Хятадын ХМХ-ийн суртал ухуулгын бодлогыг шүүмжилж, Хятадын зөөлөн хүчний бодлого үнэт зүйлсээр дамжин бус, төрийн хатуу хяналттай, нэг чигт мэдээлэл түгээх шинжтэй тул “soft” гэхээсээ илүү “sharp” байдалд илүү ойр хэмээсэн (Shambaugh.D., 2013) бол Ж.Най Хятад улс зөөлөн хүчийг хэрэгжүүлэхийг оролдож байгаа ч, “хүртээмжтэй, ил тод, чөлөөт харилцаа” дутагдаж байгаа тул түүний хүчин зүйлийг хурц хүч рүү шилжүүлж байна хэмээн тус тус шүүмжилдэг (S.Nye, 2021).

Хятад улс олон улсын тавцанд нэр хүндээ өсгөх, үзэл санаагаа түгээхэд зөөлөн хүч ашиглахаар зорьж байгаа боловч, практикт төрийн хяналттай мэдээллийн бодлого, ашиг сонирхолд нийцүүлсэн контент түгээх арга замаар хурц хүчний онцлогийг түгээмэл хэрэгжүүлж байна. Иймд, судалгааны хувьд Хятадын ХМХ-ээр хэрэгжүүлж буй бодлого нь зөөлөн ба хурц хүчний огтлолцол дээр оршиж буй хослогдсон стратеги гэж дүгнэж болох юм. China Global Television Network (CGTN) Хятадын төрийн мэдлийн гадаад мэдээллийн сувгуудын нэг бөгөөд англи, испани, араб, франц, орос зэрэг хэл дээр мэдээлэл цацдаг. Тус телевизийн үндсэн зорилго нь Хятадын талаарх олон улсын ойлголтыг эерэг болгох, “Хятадын өгүүлэмжийг дэлхийд хүргэх” буюу “telling China’s story well” гэсэн зөөлөн хүчний стратегийн хэсэг юм (Zhao Q. , 2012) (Zhao, 2015). CGTN нь Хятадын соёл, эдийн засаг, түүх, дэвшилтэт технологи, гадаад бодлогын талаарх эерэг дүр зургийг дэлхий дахинд хүргэх зорилготой. Тус телевиз олон улсын үзэгчдэд зориулан дэлхийн үйл явдлын Хятадын байр суурийг тайлбарлах, олон соёлт орнуудад Хятадтай холбоотой мэдээллийг илүү ойлгомжтой хэлбэрээр дамжуулахыг эрмэлздэг. Соёлын дипломатын нэг хэлбэр болж, зөөлөн хүчний “харилцан ойлголцлын гүүр” үүргийг гүйцэтгэдэг. Гэхдээ CGTN-ийн агуулга, мэдээлэл түгээх арга нь зөөлөн хүчнээс гадна хурц хүчний шинж агуулдаг гэдгийг олон улсын судлаачид онцолдог. CGTN-ийн мэдээ мэдээлэл Хятадын Коммунист Намын бодлогыг шүүмжлэхээс зайлсхийж, засгийн газрын чиг шугамд нийцсэн, нэг талыг баримталсан агуулгатай байдаг. Үзэл суртлын чиглэлтэй өгүүлэмж буюу Хятадын дотоод улс төр, хүний эрх, Хонконг, Тайвань, Шинжаан зэрэг маргаантай асуудлаар төрийн зөвтгөх үзэлтэй хандлага давамгайлдаг. CGTN нь Африк, Латин Америк зэрэг бүс нутагт тусгай хөтөлбөрүүдээр дамжуулан Хятадын хөгжлийн загварыг сурталчилж, барууны хэвлэл мэдээллийн давамгайлалд өрсөлдөх хандлагатай байдаг (Brady, 2015). Жишээлбэл, CGTN Africa Найробид төвтэйгээр ажилладаг бөгөөд Хятадын гадаад бодлогын “өөдрөг, найрсаг” дүр төрхийг бүрдүүлэхэд анхаардаг. Гэхдээ, Хятадын хөрөнгө оруулалтын талаарх сайшаасан контент түлхүү нийтэлдэг ч, тэдгээрийн ард буй өр, байгалийн нөөцийн хамаарал, ажил эрхлэлтэд үзүүлэх сөрөг нөлөөг огт дурдахгүй байх тохиолдол элбэг. Зарим судлаачийн үзэж буйгаар, энэ нь мэдээллийн тэнцвэргүй байдал үүсгэж, хурц хүчний илрэл болж байна (Wekesa, 2014). CGTN зөөлөн хүчийг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл мэт харагддаг боловч, түүний мэдээллийн хяналттай бүтэц, үзэл сурталжсан агуулга, гаднын үзэгчдийн сэтгэлзүйд нөлөөлөх зорилготой хөтөлбөрүүд нь тус сувгийг зөөлөн бус харин хурц хүчний хэрэгсэл болгон хувиргаж байна. Иймээс CGTN нь зүгээр нэг соёл түгээгч биш, харин Хятадын геополитикийн зорилго бүхий мэдээллийн зэвсэг болж байгааг судлаачид онцолдог.

Ж.Най зөөлөн хүчний гол түлхүүр бол иргэний нийгэм, чөлөөт соёлын орчин гэж үзсэн юм. Өөрөөр хэлбэл, төрөөс хэдий идэвхтэй оролцсон ч, бодлогын амжилт зөвхөн иргэний нийгмийн идэвхтэй оролцооноос хамаардаг гэж тэрбээр Хятадын зөөлөн хүчний бодлого хэрэгжилт хязгаарлагдмал байгааг тайлбарлан шүүмжилсэн (S.Nye, 2023)

“Хятадын аюул занал” хэмээх ойлголт олон улсад түгэхээс сэргийлж, Хятадын төр засгаас олон тэрбум ам.доллар зөөлөн хүчний бодлогод хуваарилах болж, мянга мянган судалгаа, өгүүлэл, хурал, илтгэл зөөлөн хүчний талаар хятадын судлаачид бичиж, зохиж, Күнзийн институтууд, хөгжлийн хөтөлбөрүүд, соёлын арга хэмжээ, Хятадын хэвлэл мэдээллийн сувгуудыг гадаадад өргөтгөх зэрэг олон санаачилга гаргасаар байгаа ч, Хятадын зөөлөн хүчний амжилт хязгаарлагдмал байгаа нь зөөлөн хүчний индексээр идэвхтэй урагшилж байгаа ч, бодит үр дүнгийн нөлөөлөл тодорхойгүй хэвээр байгаа нь төрөөс хэт их суртал ухуулга хийж буйтай холбоотой. Ж.Найн үзсэнээр төрөөс хэт оролцож, мэдээллийг хянаж, нийгмийн дуу хоолойг дарах юм бол зөөлөн хүчний гол зорилго болсон татах нөлөө үүсэхгүй (S.Nye, 2023). Зөөлөн хүч амжилттай хэрэгжүүлж буй ихэнх улс орны зөөлөн хүч төрөөс бус, харин иргэний нийгмээс гардагтай холбоотой байна.

Анх Ж.Найн судалгааны эргэлтэнд оруулсан зөөлөн хүчний ойлголт ийн цаг хугацааны аясаар улам бие даасан онолын түвшинд хөгжсөн бөгөөд зөөлөн хүчний бодлогын онолын судалгаа болон улс төр дэх практик хэрэглээнд дараах нийтлэг үзэл зарчмууд хадгалагдаж байдгийг судлаач И.Бакалов онцолсон нь:

1. Хилийн чанад дахь зорилтот үзэгчдийн хандлагыг өөрчлөх замаар хэрэгждэг
2. Харьцангуй урт хугацааны нөлөөтэй, ерөнхий зорилгод чиглэдэг
3. Зөвхөн төрөөс хамаарахгүй, иргэний нийгэмтэй хамт бий болдог зэрэг юм (I.Bakalov, 2019).

Мөн судлаач Дэвид Боулдин “Ж.Найн зөөлөн хүчний тухай хэлэлцүүлэг нь бодлого боловсруулагчид болон эрдэмтдэд тусгалаа олж, зарим нь зөвөөр, зарим нь буруу ойлгосон ч, бүгдийг нь урамшуулсан” гэж зөөлөн хүчний онолын үр дүнтэй байдлыг сайшааж байв (D.A.Baldwin, 2016).

Зөөлөн хүч бол олон улсын харилцаанд шинэ хэрэгсэл биш, харин шинэ өнцгөөс, шинэ нэр томъёогоор тайлбарласан, ирээдүйд улам л чухал болох татах хүчний тухай ойлголт бөгөөд үүнд онолын түвшинд хөгжүүлсэн Ж.Найн гавьяа их юм.

Хятадын онцлогтой зөөлөн хүчний онолын судалгаа

Зөөлөн хүчний онолыг анх Жозеф Най 1990 онд дэвшүүлэхдээ бусдад нөлөөлөхдөө хүч хэрэглэхгүйгээр, харин соёл, үнэт зүйл, гадаад бодлогын татах хүчинд тулгуурлан нөлөөлөх чадвар гэж тодорхойлсон. Зөөлөн хүчний гол гурван тулгуур нь: (1) соёл - хэрэв бусдад сонирхол татахуйц байвал, (2) улс төрийн үнэт зүйлс - дотоод, гадаадад үнэнч байдал хадгалбал, (3) гадаад бодлого - бусдын хувьд ёс суртахуунтай, хууль ёсны байдал юм (S.Nye, 1990).

Хятад улс энэ онолын суурийг өөрийн улс төр, соёлын тогтолцоонд нийцүүлэн тайлбарладаг. Сүүлийн жилүүдэд Хятад өөрийн гэсэн үндэсний онцлог бүхий зөөлөн хүчний бодлогын онолын үзэл баримтлалтай болоход ихэд анхаарч байна. Тухайлбал, Чэн Юмин зөөлөн хүч бол БНХАУ-ын өнөөгийн гадаад харилцаан дахь чухал нэгэн арга юм гэж тодотгосон (程玉敏, 2013). Мөн Ли Лин, Лэн Хонгтао нар үндэсний “зөөлөн хүч”-ийг нэмэгдүүлэхийн тулд боловсролоор дамжуулан үнэт зүйлсээ түгээх нь чухал гэж дүгнэсэн (Li Lin, 2017). БНХАУ-ын судлаач Ин Фань “зөөлөн хүч”-ний онолыг үзэл баримтлал нь маш тодорхой хэрэгжиж байгааг хэмжиж болох нөхцөлд л тааламжтай хэрэгсэл болгон ашиглаж болно гэсэн дүгнэлтийг хийсэн (Fan, 2008, p. 148). Өөрөөр хэлбэл, зөөлөн хүчний ойлголт өөрөө тодорхой байх шаардлагатай гэсэн.

Хятадын зөөлөн хүчний онолын судалгаа нэг талаас уламжлалт Күнзийн суртлыг дахин сэргээх, нөгөө талаас Хятадын олон улсын манлайллыг хангахад практик үнэ цэнэтэй гадаад бодлогын нөөц талаас хийгдэж байна. Энэ нь БНХАУ өөрийн үндэсний онцлог бүхий үзэл санаагаар зөөлөн хүчний онолыг баяжуулж, бие даасан үзэл баримтлалтай болохыг хичээж буйн илрэл мөн (Г.Баасанхүү, 2021).

Хятадын нэр хүндтэй судлаачид, бодлого тодорхойлогчдын бүтээлүүдээс харахад тус улсын зөөлөн хүч Барууны либерал ардчиллын үнэт зүйлд тулгуурладаггүй, харин өөрийн түүх, философи, ёс зүй, хөгжлийн загварт үндэслэдэг онцлогтой. Тухайлбал, Хятадын зөөлөн хүчний хөгжлийн талаар Хятад судлаачид “өрнөдийн загварыг хуулбарлах бус, Хятадын түүх, соёл, нийгмийн онцлогт суурилсан өөрийн загварыг бий болгох шаардлагатай” хэмээн шүүмжлэлтэй ханддаг. Жао Чижэн зөөлөн хүчийг “улс орны тухай үнэн бодит, эерэг түүхийг дэлхий дахинд өгүүлж чаддаг чадвар” хэмээн тодорхойлж, Хятад улс өөрийн дотоод үнэ цэнэ, соёлыг ил тод, нээлттэй байдлаар түгээх ёстой гэж үздэг (Zhao Q. , 2012). БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Хэвлэл мэдээллийн газрын дарга асан тэрбээр “Хятадын түүхийг сайн өгүүлэх” (讲好中国故事) нь олон улсын ойлголтыг төлөвшүүлэх үндэс хэмээн тэмдэглэж, үнэн бодит бөгөөд тод түүхүүдээр дамжуулан Хятадын соёл, түүх, энх тайвч хөгжлийг дэлхийд таниулахыг уриалсан байдаг. Түүний үзэж буйгаар зөөлөн хүч гэдэг нь зөвхөн соёлоо экспортлох биш, харин харилцаа, ойлголцлоор дамжуулан итгэлцэл бий болгох явдал юм (Zhao Q. , 2012).

Харин Хятадын олон улсын харилцааны нэрт онолч Ян Шуэтон зөөлөн хүчийг илүү ёс суртахууны талаас тайлбарладаг. Тэрбээр “ёс суртахууны реализм” (moral realism) хэмээх үзэл санаандаа Хятадын зөөлөн хүч нь соёлын сэтгэл татам байдлаас гадна ёс суртахууны манлайлал үзүүлэх чадварт оршдог хэмээн онцолжээ. Түүний үзэж буйгаар хүчирхэг улс нь бусдад таалагдах материаллаг өгөөж төдийгүй, ёс суртахууны үнэт зүйлсийг ч санал болгох ёстой бөгөөд эдгээр нь “сайн санаа” (仁), “зөв засаглал” (义) зэрэг Конфуцийн суртлын ойлголтод

үндэслэгддэг (Xuetong Y. , 2011). Ян Шуэтон зөөлөн хүчийг зөвхөн соёлын түвшинд ойлгохоос илүүтэйгээр “ёс суртахууны удирдлагын чадвар” буюу ёс суртахууны өндөр үнэт зүйлсийг дэлхийд санал болгох чадвар гэж тодорхойлсон нь онцлогтой.

Хятадын зөөлөн хүчний стратеги нь нийтлэг, бодитой байх шаардлагатай бөгөөд төрийн санаачилгууд (жишээ нь, Күнзийн институт, CGTN зэрэг) болон төрийн бус оролцогчид (жишээ нь, кино урлаг, технологийн компаниуд болох Huawei, Alibaba) хоёуланг багтаасан байх ёстой гэж үздэг. Түүний “Soft Power: China's Emerging Strategy in International Politics” бүтээлд Хятадын хөгжлийн загвар, эдийн засгийн амжилт нь хөгжиж буй орнуудад Барууны либерализмаас илүү сэтгэл татам сонголт болж байгааг тайлбарласан (Li M. , 2009). Тэрбээр зөөлөн хүчийг Хятадын гадаад бодлогын “дэмжих механизм” гэж нэрлэж, зөөлөн хүчний үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд төрийн бодлого, олон нийтийн санаачилга, соёлын институт хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх ёстой гэж дүгнэсэн байдаг (Li M. , 2009).

Мөн Ван Ивэй Хятадын зөөлөн хүч “соёлын хөрөнгө оруулалт, Күнзийн институт, гадаад сурталчилгааны харилцаа” зэрэг бодит хэрэгслээр дамжин хэрэгждэг бөгөөд энэ нь Хятадын зөөлөн хүчийг “хөгжлийн зөөлөн замнал” болгон таниулах стратеги хэмээн тайлбарладаг (Wang Y. , 2012). Тэрбээр “иргэншлийн улс” (文明型国家) гэсэн ойлголтыг онцолж, Хятадын урт удаан түүх, философи, эв найрамдлын ертөнцийг үзэх үзэл нь тус улсын дэлхийн дүр төрхөд чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэдэг. Мөн Хятад улс зөөлөн хүчээ “иргэншлийн итгэл үнэмшил”, хамтын үнэт зүйлс (жишээ нь, эв нэгдэл – 和, харилцан хүндлэл, энх тайван зэрэгцэн оршихуй) зэргээр дамжуулан түгээж байгаа ба энэ нь “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд тод харагдаж байна гэж үздэг (Wang Y. , 2016). Түүний үзэл бодлоор энэ нь Барууны үнэт зүйлс давамгайлсан хандлагад өгөх сөрөг өгүүлэмж (counter-narrative) юм.

Хятадын дотоод бодлогын түвшинд ч зөөлөн хүчийг албан ёсоор төрийн бодлогод шингээсэн. Тухайлбал, БНХАУ-ын ХКН-ын 18 дугаар их хурал (2012)-аас хойш Хятадын дарга Си Жиньпин “улсын соёлын зөөлөн хүчийг нэмэгдүүлэх” (提高国家文化软实力) зорилтыг “Хятадын мөрөөдөл” болон Хятадын сэргэн мандалтын стратегийн нэг хэсэг болгон тодорхойлсон. Албан баримт бичгүүдэд “соёлын итгэл үнэмшил” (文化自信) нь улсын хүч чадал, олон улсын нэр хүндийн эх сурвалж гэж дурдагддаг.

Хятад судлаачдын дийлэнх нь соёлыг зөөлөн хүчний гол цөмд тавьдаг онолын “соёлын сургууль”-д (вэнхуа пай 文化派) хамрагддаг. Хятадын зөөлөн хүчний онолчид соёлын сургуулийг үүсгэж, “соёлын зөөлөн хүч” (энэ нь зөөлөн хүчтэй ижил утгатай болсон) үзэл баримтлал үүсгэсэн нь Ху Жинтаогаас эхлээд Си Жиньпин хүртэл дээд удирдагчдын олон удаагийн уриалга, илтгэлд дурдагдан дэлгэрснийг харж болно. Ухуаний их сургуулиас эрхлэн

гаргадаг шинэ сэтгүүл “Соёлын зөөлөн хүч” (wenhua ruanshili 文化软实力) гэсэн гарчигтай байсан нь энэхүү судалгааны ажлын тулгамдсан шинжийг илэрхийлж байна. (Repnikova, 2022)

Хятадын Олон улсын хэвлэлийн ерөнхийлөгч Жөү Минвейн илтгэлүүдэд Хятадын болон Барууны соёл, үнэт зүйлсийн нийцэл, нийтлэг чанаруудыг олохын чухлыг онцлон тэмдэглэсэн ба барууны үзэгчдэд үнэхээр таалагдахуйц Хятадын соёлын бүтээгдэхүүн хөгжүүлэх шаардлагатайг дурдсан байдаг. Жөү хэлэхдээ, Хятад улс соёлын бүтээгдэхүүн, уран зохиолыг дэлхий дахинд танилцуулахдаа Хятадын соёл болон дэлхийн бусад соёлын хоорондын уялдаа, нийтлэг үнэт зүйлст илүү анхаарах хэрэгтэй гэжээ. Мөн Хятад улс бусад соёлыг, ялангуяа хөгжиж буй орнуудын соёлыг ойлгоход илүү цаг, хүч зарцуулах шаардлагатай гэж үзэж байна. Хятадын соёлыг “гадаад руу гаргах” стратеги нь зөвхөн дотоодын үзэгчдийг хөгжөөхөөс илүүтэйгээр төлөвлөгөөтэй, системтэй хандлага шаарддаг. Хятадын түүхийг дэлхийд илүү сайн өгүүлэхийн тулд зах зээлд төвлөрч, соёлын бүтээгдэхүүнийг зорилтот үзэгчдэд тохируулан бүтээх нь чухал хэмээн тэрээр онцолсон (周明伟, 2012).

Хятадын үндэсний онцлогтой зөөлөн хүчний онолын үндсийг бүрдүүлэхээр идэвхтэй судалгаа хийгдэж эхлэх үед Хятадын Коммунист Намын Төв Хорооны Олон улсын стратегийн судалгааны төвийн орлогч захирал Мен Хунхуа Хятадын зөөлөн хүчийг бэхжүүлэхэд шаардлагатай таван үндсэн хүчин зүйлийг онцлон дурдсан нь

1. Хатуу хүч бол суурь хүчин зүйл хэвээр үлдэх хэрэгтэй;

Хятадын хувьд хатуу хүчийг цаашид нэмэгдүүлж, илүү ухаалаг ашиглах, түүний нөлөөг бэхжүүлэх нь чухал. Үүний зэрэгцээ олон улсын чухал арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх болон дотоодын соёлын хөгжлийг дэмжих замаар зөөлөн хүчний хөгжлийн материаллаг суурийг бүрдүүлэх хэрэгтэй;

2. Уламжлалт Хятадын соёлыг идэвхтэй сурталчлах шаардлагатай;

Хятадын уламжлалт соёлыг хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн загвар, олон улсын байгууллага, Хятадын имижийг хөтлөгч болгон ашиглах хэрэгтэй. Зөөлөн хүчний талаарх хэлэлцүүлэг нь үнэндээ уламжлалт соёлыг орчин үетэй уялдуулан шинэчлэх тухай асуудал юм;

3. Хятадын хөгжлийн загварыг сайжруулах, оновчтой болгох ёстой;

Тодорхой хэмжээнд Хятадын хөгжлийн загварын амжилт нь зөөлөн хүчний нөлөөнөөс хамаарна;

4. Олон улсын байгууллага дах оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй;

Хятад улс олон улсын байгууллагын хэлэлцэх асуудлыг тодорхойлох чадамжтай болоход энэ чухал бөгөөд Хятад улс дэлхийн хамтын нийгэмлэгийн илүү идэвхтэй оролцогч болохыг эрмэлзэх нь зүйтэй. Бүс нутаг болон дэлхийд нөлөөтэй байхыг хүсвэл олон улсын нийтийн сайн сайхны төлөө илүү их хувь нэмэр оруулах шаардлагатай; Зүүн Азийн бүс нутагт олон улсын байгууллагуудыг шинэтгэхэд түлхэц үзүүлэхэд энэ нь чухал суурь болно;

5. Дотоод имижийг сайжруулж, олон улсын имижийг өргөжүүлэхийн төлөө Хятад улс өөрийн ард түмэн, улсдаа хариуцлагатай байх ёстой.

“Эв нэгдэлтэй нийгэм”-ийг хөгжүүлж, эерэг дотоод болон олон улсын имиж бүрдүүлэх нь зайлшгүй” гэсэн бодлогын саналыг дэвшүүлж байв (作者簡介, 2011).

Хятадын Улс төр, Хуулийн Их сургуулийн “Глобалчлал ба дэлхий дахины асуудлууд” хүрээлэнгийн захирал Цай Туо ХХI зуунд Хятадын гадаад бодлогын гол чиглэл нь зөөлөн хүчийг бэхжүүлэх, үр дүнтэй ашиглах чадамжтай байх ёстой гэж үздэг. Түүний үзлээр зөөлөн хүч нь Хятадын уламжлалт соёлын салшгүй хэсэг бөгөөд Хятадын үндэсний хүч 1840 оны хар тамхины дайнаас хойш суларсан боловч зөөлөн хүчний суурь болсон үнэт зүйлс, үзэл санаа, соёл бүрэн устаж алга болоогүй. Иймд үндэсний соёлын өвд тулгуурлан зөөлөн хүчийг хөгжүүлэх хэрэгтэй гэсэн (Туо, 2012). Зөөлөн хүчийг бэхжүүлэх нь Хятадын эерэг имиж бүрдүүлэх болон глобал байр суурийг тогтоох чухал үндэс гэж тэр үздэг.

Энэ мэт Хятадын судлаачдын соёлын зөөлөн хүчний тухай онолын судалгаа өнөөгийн Хятадын өсөн нэмэгдэж буй зөөлөн хүчний зорилго, нөөц, хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлоход үнэ цэнтэй хувь нэмэр оруулсан гэж үзэж болно.

Хүснэгт 2: Хятадын зөөлөн хүчний зорилго

Хятадын зөөлөн хүч	
Гол санаа	“Ёс суртахуун”-ыг ашиглан төрөө удирдаж, дэлхийд шударга ёс, сайн үйлсийг авчрах 以德--治 国, 平天下
Зорилго	Хятадын соёлын өвөрмөц байдлыг бэхжүүлэх Хятадын олон улсын дүр төрхийг сайжруулах (Хятадын дуу хоолойг санал болгох замаар) Хятадын соёл, Хятадын загварыг сурталчлах (Олон туйлт) дэлхийн засаглалын нэг хэсэг байх
Хэрэгжүүлэх нөөц	Соёл (хэл, өв, түүх, үндэсний үзэл) Хятадын ёс суртахууны үнэт зүйлс (социалист эв хамт гэх мэт үндсэн үнэт зүйлс) Гадаад бодлого (худалдааны хэлэлцээр/эдийн засгийн хамтын ажиллагаатай холбоотой)

XXI зуун гарсаар БНХАУ-ын удирдлага үндэсний цогц хүч чадлыг олж авахад зөөлөн хүчний чухал үүргийг хүлээн зөвшөөрч, соёл нь түүний зөөлөн хүчний гол цөм юм гэсэн гол эрдэм шинжилгээний үзэл баримтлалыг баримталжээ. Өнөө үед Хятадын уламжлалт соёл нь хүчтэй, сонирхол татсан хэвээр бөгөөд зөөлөн хүчний онол нь Хятадын уламжлалт соёлтой нийцэж байгаа. Хятадын зөөлөн хүчний бодлого соёлыг онцолж, заналхийлэл хүч хэрэглэх явдлыг түр зуурын, гол төлөв реактив шинжтэй гэж үздэг.

Хятадын зөөлөн хүчний онолын хандлага нь Хятадын зөөлөн хүчийг улс төрийн төвлөрсөн систем, соёлын онцлог, ёс суртахууны манлайлалд тулгуурлан хэрэгжүүлэхийг зорьдог болохыг харуулж байна (Д.Уянга & Ж.Баттөр, 2024).

Хятадын зөөлөн хүчний онол Жозеф Найн тодорхойлсон барууны зөөлөн хүчний үзэл санаанд үндэслэж хөгжсөн боловч төрөөс хянан удирддаг, үндэсний соёл, түүх, үзэл суртлын элементүүдийг онцолдог, иргэний нийгмийн оролцоо бага бөгөөд БНХАУ-ын зөөлөн хүчний үндэс нь иргэний нийгэм бус, төрийн санаачилгатай соёлын дипломат бодлого гэдгээрээ онцлог ялгаатай гэж дүгнэж болно.

Хүснэгт 3: Хятадын зөөлөн хүчний загварын онцлог

Хятад загвар	Барууны (Ж. Най) загвар
Төр төвтэй, чиглүүлдэг	Иргэний нийгэм, соёл төвтэй
Үзэл суртал давамгайлсан	Ардчилал, хүний эрх дээр суурилсан үнэт зүйлс
Улс төрийн стратеги давамгайлсан	Нээлттэй байдал, татах хүчний сэтгэлзүй давамгайлсан
Үр дүнг хэмжихэд төвөгтэй	Тодорхой судалгаанд тулгуурлан үр нөлөөг тооцдог

Эдгээр байр суурийг нэгтгэн харахад Хятадын зөөлөн хүчний үзэл баримтлал нь Хятадын улс төрийн соёл, Күнзийн уламжлал, хөгжлийн үзэл суртал, төвлөрсөн төлөвлөлтөд гүн гүнзгий суурилсан бөгөөд Барууны либерал хандлагаас эрс ялгарч байна. Барууны орнууд хувь хүний эрх чөлөө эсвэл поп соёлыг голчилдог бол Хятадын эрдэмтэд эртнээс улбаат соёл, хамтын эв нэгдэл, түүхэн гүн гүнзгий байдал, хөгжлийн амжилт зэрэг үнэт зүйлсийг зөөлөн хүчнийхээ тулгуур болгон онцолдог. Эдгээр байр сууриудаас харахад Хятадын зөөлөн хүч Барууны “татах нөлөөтэй” зөөлөн хүчнээс ялгаатайгаар, “үндэсний соёлоор бахархсан” “төрөөс удирдсан, хөгжлийн хэв маягаа түгээх зорилготой” гэсэн онцлог шинжийг агуулж байна.

Сэдвийн хэлэлцүүлэг

Хятадын зөөлөн хүчний талаарх сонирхол 1990-ээд оны сүүлээс идэвхитэй илэрч гарсан. Тухайлбал, 1993 онд тухайн үеийн Хятадын удирдагч Жян Зэминь (Jiang Zemin)-ийн зөвлөхөөр

ажиллаж байсан Ван Хунин (Wang Huning) хэмээх Фуданы их сургуулийн профессор “зөөлөн хүчний” талаархи анхны академик нийтлэлийг бичсэн гэж тэмдэглэгдсэн байдаг (Huning, 1991).

Зөөлөн хүчийг хэрэгжүүлэх оролдлогууд нь 2004, 2005 онд БНХАУ-ын дарга асан Ху Жинтао “эв зохицолтой нийгэм”, “эв зохицолтой ертөнцийг” бий болгохыг зорьж буй өөрийн хүсэл эрмэлзлэлээ олон нийтэд зарласнаас эхэлсэн. Ху Жинтао “эв нэгдэлтэй ертөнц гэдэг нь олон талт харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа, оршин буй соёл иргэншлүүд хийгээд шинэчлэгдсэн НҮБ дэлхий ертөнцийг цогцлоох сэтгэлээр хамтран аж төрөхийг хэлнэ” гэж тодорхойлсон (Buzan, 2010). 2007 онд Ху Жинтао БНХАУ-ын ХКН-ын 17-р их хуралд илтгэл тавихдаа Хятадын “зөөлөн хүч”-ийг бий болгох зорилгоо илэрхийлсний дараа Хятадын зөөлөн хүчний талаархи шийдвэр гаргах хэлэлцүүлэг улам бүр цогц болсон юм. Ийнхүү зөөлөн хүчний талаарх сонирхлоо илэрхийлсэний үр дүнд, эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд олон тооны өгүүлэл болон Хятадын тогтмол хэвлэлүүд ч энэ талаар идэвхтэй нийтлэгдэж, мөн албан ёсны судалгааны төвүүдийн зөөлөн хүчний талаархи судалгааны нууц төслүүд хэрэгжсэний дотор Намын төв сургуулийн Стратегийн судалгааны хүрээлэн, Хятадын орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэн (CICIR) багтаж байв (Gil, 2017).

Си Жиньпин даргын үед Бээжин зөөлөн хүчинд улам ихээр анхаарал хандуулах болсон. 2014 онд Си Жиньпин зөөлөн хүчийг хөгжүүлэх замаар тухайн улсын олон улсын тавцанд харилцах чадвар болон харилцаа холбооны сайн тогтолцоог бүрдүүлэх зорилгодоо хүрнэ гэж мэдэгджээ. Түүнчлэн тэрээр шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүтээлч чадвараа нэмэгдүүлэн Хятадын түүх, дуу хоолой, онцлог шинж чанарыг сайтар тайлбарлаж Хятадыг сурталчлах үүргийг хүлээх ёстой гэжээ (Beith, 2022).

Си Жиньпиний санаачилгаар БНХАУ “Ази, Номхон далайн мөрөөдөл”, “Хятад мөрөөдөл”, “Хорин нэгдүгээр зууны далайн торгоны зам”, “Торгоны замын эдийн засгийн бүс”, “Томоохон орнуудын харилцааны шинэ хэлбэр” гэх мэт олон шинэ санаачилгыг дэлхий нийтэд танилцуулсан. Эдгээр санаачилгуудыг “Уриа лоозонгийн шинжтэй дипломат ажиллагаа” хэмээн тодорхойлоход хялбар боловч Хятадын зүгээс тун өндөр ач холбогдол өгч байна (Shambaugh.D., 2013).

Олон улсын тавцанд Хятадын зөөлөн хүчний бодлогыг түгээн дэлгэрүүлэхэд түлхэц болж буй хүчин зүйлсийг дурьдвал:

- Эдийн засгийн асар хурдацтай өсөлт нь дэлхийн зах зээл дээрх байр сууриа бататгах боломж болдог.
- Хөрш орнууд тэр дундаа Азийн орнуудтай харилцаагаа өргөжүүлэн тэлэх нь чухал гэдгийг БНХАУ хүлээн зөвшөөрдөг.
- Хятадын Өмнөд тэнгисийн маргаанаас ажиглахад хатуу хүч хэрэглэх нь зорилгодоо хүрэх зохистой арга биш гэдгийг ойлгосон г.м

Сүүлийн жилүүдэд гадаад худалдааг дэмжих, Азийн орнуудад тусламж үзүүлэх, бүс нутгийн байгууллагуудыг бий болгох замаар Хятадын нөлөө Азид улам бүр нэмэгдсээр байна. Ингэснээр эдийн засаг, цэргийн хүч өсөхийн зэрэгцээ Хятад зөөлөн хүчээ бэхжүүлж улс орны бүс нутгийн нөлөөг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэн Азийн бүс нутагт АНУ-тай эн зэрэгцэх хүчтэй өрсөлдөгч болсон (S.Nye, 2023).

Судалгааны үр дүнд тулгуурлан Хятадын зөөлөн хүчний загварыг бүрэлдэхүүн буюу элементийг дараах бүрдлээр тодорхойлж болох юм. Үүнд:

Хүснэгт 4: Хятадын зөөлөн хүчний бодлогын бүрэлдэхүүн хэсэг

Бүрэлдэхүүн хэсэг	Агуулга
1. Үнэт зүйл, үзэл суртал	“Хятад мөрөөдөл”, ХКН-ын үнэт зүйлс
2. Соёлын экспорт	Кино, Хятад хэл, соёл (Күнзийн институтууд), уламжлалт анагаах ухаан, түүх, уран зохиол
3. Эдийн засгийн зөөлөн нөлөө	“Бүс ба зам” санаачилга, хөгжлийн тусламж, хөрөнгө оруулалт
4. Олон улсын мэдээллийн бодлого	Хятадын олон улсын хэвлэл мэдээлэл (CGTN, China Daily)
5. Хуулийн болон институцийн орчин	Олон нийтийн дипломат ажиллагаа хэрэгжүүлэгч төрийн мэдээллийн бодлого, суртал ухуулгын төвлөрсөн бүтэц

Зөөлөн хүчний бодлогыг бодит болгохын тулд эдийн засгийн үлэмж хэсгийг Хятад улс дотооддоо болон гадаадад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, соёл, урлагийн байгууллагыг дэмжихэд ашиглах болсон. Мөн үүгээрээ БНХАУ бусад олон орны хөгжлийн тусламж, засгийн газрын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдэд гол үүрэг гүйцэтгэх боломжтой юм. (Lewis, 2023)

Хүснэгт 5: Хятадын зөөлөн хүчний бодлого хэрэгжиж буй хэлбэр

Шатлал	Зөөлөн хүчний хэрэгжих хэлбэр
1. Улс төрийн	Төрийн бодлогоор удирдуулсан, төвлөрсөн зохион байгуулалттай сурталчилгаа
2. Соёлын	Уламжлалт соёл, хятад хэлний сурталчилгаа (Күнзийн институт, соёл боловсролын хөтөлбөрүүд)
3. Эдийн засгийн	Хөгжлийн тусламж, хөрөнгө оруулалттай хамт “найрамдалт” имиж бүрдүүлэх
4. Олон нийтийн мэдээллийн	Гадаад оронд чиглэсэн хянагдсан мэдээлэл, стратегийн PR


Дүгнэлт

Хятадын зөөлөн хүчний судалгаанууд Ж.Найн дэлхий нийтийн анхаарлыг татах замаар хүч чадлыг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй нийцдэг. Ж.Най хатуу ба зөөлөн хүчийг ялгаж салгадаг бол хятад судлаачид ихэвчлэн энэ хоёрыг нэгтгэдэг бөгөөд өдөөгч хүчин зүйлүүдээс шалтгаалан

энэ хоёрын таталцал салшгүй гэж үздэг бөгөөд энэ нь хятадын уламжлалт гүн ухааны үзэлтэй салшгүй холбоотой.

Хятадын зөөлөн хүч хэрхэн бүрэлдэж, гадаад орнуудад нөлөөлж буйг механизмын шалтгаан-үр дагаврын гинжин холбоогоор харуулахыг хичээлээ.

Бүдүүвч1: Хятадын зөөлөн хүчний бүтцийн загвар ба үйл ажиллагааны урсгал



Ж.Най зөөлөн хүчний эх үүсвэрийг гадаад бодлого, үнэт зүйл, соёл гэж танилцуулдаг бол Хятадын судалгаануудад үүнийг үзэл суртлаас эхлээд үнэт зүйл, эртний түүх, үндэсний оюун санаа, засаглалын үйл ажиллагаа, эдийн засгийн чадавх гэх мэт онцлог шинж чанаруудын холимог байдлаар харуулдаг.

Онолын хувьд Хятадын эрдэм шинжилгээний болон бодлогын бичвэрүүд зөөлөн хүчний дотоод болон гадаад чиг баримжаа, Хятадын соёлын нэг хэсэг болох социалист үнэт зүйлс, үзэл суртлын ач холбогдол, Си-гийн санааг нэгтгэж, бататгах хандлагатай байна.

Бүхэлдээ Хятадын зөөлөн хүчний онол нь төвлөрсөн төрийн бодлого, улс төрийн үзэл суртал, соёл, эдийн засгийн уялдаа, мэдээллийн хяналт зэргийг нэгтгэсэн, төр төвтэй зөөлөн хүчний загвар гэж тодорхойлж болно. Барууны модель ардчилсан үнэт зүйл, иргэний нийгмийн идэвхтэй оролцоонд тулгуурладаг бол Хятадын загвар нь төрөөс “татах хүч”-ийг төлөвлөдөг, хянадаг, түгээдэг шинжтэйгээрээ ялгарч байна.

НОМ ЗҮЙ:

Нэг сэдэвт бүтээл:

1. Arif, B. H. (2017). *The Role of Soft Power in China's Foreign Policy in the 21st Century*.
2. Beith, T. D. (2022). *The Dragon's Silver Tongue: Chinese Soft Power in the Age of Xi Jinping*. Viro.
3. Chen, G. C. (2009). *Soft Power: China's Emerging Strategy in International Politics*. Lexington Books.
4. D.A.Baldwin. (2016). *Power and international relations: a conceptual approach*. Princeton: Princeton University Press.

5. Gil, J. (2017). *Soft power and Worldwide promotion of Chinese language learning Beliefs and Practices: The Confucius Institute Project*. Multilingual Matters.
6. Kurlantzick, J. (2022). *Beijing's Global Media Offensive: China's Uneven Campaign to Influence Asia and the World*. NY: Oxford University Press.
7. Lee, C. S. (2018). *Soft Power Made in China: The Dilemmas of Online and Offline Media and Transnational Audiences*. Incheon: Springer.
8. Lewis, A. (2023). *Chinese Television and Soft Power in Africa*. Routledge.
9. Li, M. (2009). *Soft power. China's Emerging Strategy in International Politics*.
10. Lynch, D. C. (2022). *After the Propaganda State: Media, Politics, and 'Thought Work' in Reformed China*. Stanford: Stanford University Press.
11. Repnikova, M. (2022). *Chinese Soft Power.Elements in Global China*. Cambridge University Press.
12. S.Nye, J. (2023). *Soft Power and Great Power Competition: Shifting Sands in the Balance of Power Between the United States and China*. Cambirdge: Springer.
13. Shambaugh.D. (2013). *China Goes Global: The Partial Power*. Oxford: Oxford University Press.
14. Tuo, C. (2012). *Chinese Perspectives on Globalization and Autonomy*. Leiden: Brill.
15. Xuetong, Y. (2011). *Ancient Chinese Thought, Modern Chinese Power*. Princeton: Princeton University Press.
16. Zhang, X. (2011). China's International Broadcasting: A Case Study of CCTV International. In J. Wang, *Soft Power in China Public Diplomacy through Communication* (pp. 57-71). NY: Palgrave Macmillan.
17. Zhao, Q. (2012). *The wisdom of public diplomacy : cross-border dialogues*. Beijing: New World Press.

Эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Brady, A.-M. (2015, October). Authoritarianism Goes Global (II): China's Foreign Propaganda Machine. *Journal of Democracy*, 26(4), 51-59.
2. Buzan, B. (2010). China in international society: Is 'peaceful rise' possible? . *The Chinese Journal of International Politics* , 3(1), 5-36.
3. Fan, Y. (2008). Soft power: power of attraction or confusion? *Place Branding and Public Diplomacy*, 148.
4. Flew, T. (2016, December). Entertainment media, cultural power, and post-globalization: The case of China's international media expansion and the discourse of soft power. *Global Media and China*, 1(4), 278-294.
5. Huning, W. (1991). Culture as National Strength: Soft Power. *Fudan Journal*, 3.
6. I.Bakalov. (2019). Whither soft power? Divisions, milestones, and prospects of a research program in the making. *Journal of Political Power*, 12, 129-151.

7. Kutz, M. R., & Bamford-Wade, A. (2013). Understanding Contextual Intelligence: A Critical Competency For Today's Leaders. *Emergence: Complexity & Organization*, 15(3), 55-80.
8. Li Lin, L. H. (2017). Joseph Nye's Soft Power Theory and Its Revelation towards Ideological and Political Education. *Humanities and Social Sciences*, 5(2), 69-74. doi:10.11648/j.hss.20170502.13
9. Michalski, A. (2012). China and the EU: Conceptual Gaps in Soft Power. In Z. Pan, *Conceptual Gaps in China-EU Relations: Global Governance, Human Rights and Strategic Partnerships* (pp. 65-82). Houndmills, Basingstoke: Palgrave Macmillan.
10. S.Nye, J. (1990, Autumn). Soft Power. *Foreign Policy*, 80, 153-171. Retrieved from <http://www.jstor.org/stable/1148580>
11. S.Nye, J. (2021). Soft power: the evolution of a concept. *Journal of Political Power*, 1-21.
12. Shambaugh, D. (2015). China's Soft-Power Push. *Foreign Affairs*, p. 100.
13. Walker, C., & Ludwig, J. (2017, December). From 'Soft Power' to 'Sharp Power' Rising Authoritarian Influence in the Democratic World. *International Forum for Democratic Studies*, pp. 8-25.
14. Wang, Y. (2012, January). Domestic Constraints on the Rise of Chinese Public Diplomacy. *The Hague Journal of Diplomacy*. doi:10.1163/1871191x-12341237
15. Wang, Y. (2016, 9 28). Jianghao zhongguo gushi shi shidai shiming" (Telling a Good Story of China is the Mission of an Era) . *People's Daily*. Retrieved from <http://theory.people.com.cn/BIG5/n1/2016/0928/c376186-28746111.html>
16. Wekesa, B. (2014). An analysis of China Central Television's Talk Africa Debate Show. *China and Africa Media, Communications and Public Diplomacy* (pp. 1-22). Beijing: CMI.
17. Zhao, K. (2015, Summer). The Motivation Behind China's Public Diplomacy. *The Chinese Journal of International Politics*, 8(2), 167-196.
18. Г.Баасанхүү. (2021). Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа Монгол улсын зөөлөн хүчний бодлогын арга хэрэгсэл болох нь. In Д.Уламбаяр, *Олон улсын харилцаан дах зөөлөн хүчний бодлого ба Монгол улс: Судалгаа, шинжилгээ* (pp. 232-251). УБ: Соёмбо принтинг.
19. Д.Уянга, & Ж.Баттөр. (2024). Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлог. *SPSIRPA Forum: Geopolitical Restructuring: Regional Issues and Policy Affairs* (pp. 482-493). UB: SPSIRPA, National University of Mongolia.
20. 中国社会科学出版社. (1992). *黄硕风综合国力新论*. 北京: 中国社会科学出版社.
21. 作者簡介, Z. J. (2011, 11 7). 現代中國+全球化. <http://paper.wenweipo.com>. Retrieved from <http://paper.wenweipo.com/2011/11/07/ED1111070014.htm>

22. 周明伟, Z. M. (2012, 11 9). *周明伟：中国文化走出去道路越来越宽*. Retrieved from china.com: http://www.china.com.cn/v/18da/2012-11/09/content_27060351.htm
23. 程玉敏. (2013). 文化软实力与高校国际交流合作的战略选择. *福州大学学报*(6).